

Г.ЗАНАБАЗАРЫН НЭРЭМЖИТ ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙ
ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2022 оны 02 сарын 21

№ 04

Улаанбаатар хот

2021 оны 03 дугаар сарын 18, 05 дугаар сарын 17-19, 09 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд Монгол улсын стандартын 12 дугаар зүйлийн 12.9, 17 дугаар зүйл, Музейн тухай хуулийн 7.1.2,7.1.3, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж музейн харуул, хамгаалалтын аюулгүй байдал, музейн сан хөмрөгийн өрөөний цэвэрлэгээ, хөгц мөөгөнцөр, ариутгал, аюулгүй байдал, сэргээн засварлалт, арчилгаа, үзмэрийн танхимуудын дулаан чийг, гэрэлтүүлэгт тогтмол хэмжилт хийж хяналт тавьж байгаа эсэхэд хяналт, шалгалтыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.Шалгалтаар:

1. Музейн харуулуудын байр эмх цэгцтэй, камерын хяналт хэвийн, дохиоллын систем хэвийн. Тоног, төхөөрөмжийг ажиллагааг шалгуулан хэвийн горимд оруулсан.

Музейн хашааны гэрэлтүүлэг хэвийн, хашаан дотор байрлах машины граж, ногооны хүлэмжийг шалгаж аюулгүй байдлыг хангах үүднээс шаардлагагүй хог хаягдлыг хаяж, хашааг цэвэрлэх арга хэмжээг авсан.

Музейн ариун цэврийн өрөөний усны даралт бага, жуулчин ихтэй үед ариун цэврийн өрөөний хүрэлцээ муу байдгаас музейн удирдлагын зүгээс төсөв гарган өөрсдийн нөөц бололцоог ашиглан их засварын ажил хийх гүйцэтгэх үүрэг өгсний дагуу засварын ажлыг хийж дуусгасан.

2. Цэвэрлэгээг тогтмол хийдэг, эмх цэгцтэй, үзмэрийг зориулалтын дагуу байрлуулсан, ариутгалыг стандартад заасны дагуу мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэдэг, дулаан ба чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийг тогтмол хийж тэмдэглэл хөтөлсөн байв.

Музейн үзүүлэгийн танхимын цэвэрлэгээ сайн, үзүүлэгийн танхим болон үзмэрийн хоргоны дулаан ба чийгшилт, гэрэлтүүлгийн хэмжилтийг тогтмол хийж баталгаажуулсан байна.

Шаардлагатай сэргээн засварлалтын ажлыг хийж гүйцэтгэсэн биелэлт 100 хувь байна.